



**МОНГОЛ УЛС, БНСУ ДАХЬ
ХҮМҮҮН КАПИТАЛЫН
ИНДЕКСИЙГ ХАРЬЦУУЛАХ
НЬ**

доктор (Ph.D.) профессор
Ч.УЛААН

Даяаршлын өнөөгийн эринд улс орнуудын харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр глобал эдийн засагт нэгдэж, интеграцчлагдах үйл явц эрчимтэй өрнөх болов. Ялангуяа бүс нутгийн орнуудын бие биенээ нөхсөн, харилцан нөхцөлдсөн хамтын ажиллагаа урьд өмнөхөөс илүү түргэн хурдацтай хөгжиж байна. Үүний нэгэн тод жишээ бол Зүүн хойд Азийн бүс нутаг юм. Бүс нутгийн орнууд зөрчил маргаантай асуудлаа хойш тавьж энхийг эрхэмлэж, бүс нутгийн хэмжээнд тулгамдсан асуудлаа хамтран шийдвэрлэх, эдийн засгийн өсөлт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудалд түлхүү анхаарах болжээ.





- ▶ Дэлхийн нийт хүн амын 22.3 хувь, нутаг дэвсгэрийн 21.4 хувь, үндэсний нийт орлогын 27.1 хувь нь Зүүн хойд Азийн улс орнуудад ногдож байна (*Хүснэгт 1*).
- ▶ Зүүн хойд Азийн орнуудын хүн ам 2,094.4 сая хүн, нутаг дэвсгэр 38,692.8 мян км², үндэсний нийт орлого 25,668.6 тэрбум ам.доллар, нэг хүнд ногдох дундаж ҮНО 14,781.8 ам.доллар байгаа (*БНАСАУ-ыг оруулахгүйгээр*) нь дэлхийн дунджаас 2,758.8 ам.доллар буюу 22.9 хувиар илүү байна.

Зүүн хойд Азийн орнуудын үндсэн үзүүлэлт (2018-2021 он)

№	Улс	Хүн ам, сая хүн	Нутаг дэвсгэр, мян.км ²	Хүн амын нягтрал, хүн/км ²	Үндэсний нийт орлого, тэрбум ам.доллар	Нэг хүнд ногдох ҮНО, ам.доллар	ДНБ	
							Өсөлт, %	Нэг хүнд ногдох өсөлт, %
		2021	2018	2021	2021	2021	2021	2021
Дэлхий		7,888.4	134,664.1	60.2	94,862.4	12,026.0	5.9	5.0
1.	БНХАУ	1,412.4	9,600.0	149.7	16,785.1	11,880.0	8.1	8.0
2.	Япон улс	125.7	378.0	346.4	5,360.7	42,650.0	1.7	2.1
3.	БНСУ	51.7	100.4	531.1	1,816.7	35,110.0	4.1	4.3
4.	БНАСАУ	26.0	120.5	214.8
5.	Монгол	3.3	1,564.1	2.1	12.5	3730.0	1.6	0.0
6.	ОХУ	143.4	17,098.3	8.8	1,693.6	11,610.0	4.7	5.2
7.	АНУ*	331.9	9,831.5	36.2	23,539.0	70,930.0	5.9	5.8
Зүүн Ази, Номхон далайн орнууд		2,370.2	24,867.8	96.5	30,189.2	12,737.0	5.8	5.5
Дундаас дээгүүр орлоготой орнууд		2,503.1	54,597.6	46.8	25,927.8	10,358.1	7.4	7.1
Өндөр орлоготой орнууд		1,240.6	37,488.8	35.2	59,699.6	48,120.4	5.2	5.3
Зүүн хойд Азийн орнууд**		1,762.5	28,861.3	1289.1	25,668.6	14,781.8	-	-

Дэлхийн нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний дундаж хэмжээ 2022 онд 2021 оныхоос 958,1 ам.доллар буюу 8.6 хувиар өсч, 12,026 ам.доллар байгаа бөгөөд БНСУ-ынх 2,150 ам.доллар буюу 6.5 хувь, өмнөд хөрш БНХАУ-ынх 1,330 ам.доллар буюу 12.6 хувь, умард хөрш ОХУ-ынх 920 ам.доллар буюу 8.6 хувиар өссөн байхад манай орных 10 ам.доллар буюу -2.3 хувиар буурсан ажээ. БНСУ-ын нэг хүнд ногдох ҮНБ-ний хэмжээ нь дэлхийн дунджаас 2.9 дахин их байхад манай хоёр хөршийн нэг хүнд ногдох ҮНБ-ний хэмжээ нь дэлхийн дундаж түвшингийн орчим байгаа бөгөөд манай орны нэг хүнд ногдох ҮНБ дэлхийн дундаж түвшний 1/3 орчмоос бага байна.

2018 оноос эхлэн Хүмүүн капиталын индекс (ХКИ)-ийг шинээр тооцсон бөгөөд Дэлхийн банк, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас эрхлэн “Хүмүүн капитал төсөл”-ийн гурав дахь жилийн тайланг 2021 онд гаргаад байгаа ажээ.



БНСУ дахь Хүмүүн капиталын индекс

- ▶ Цар тахлын өмнөхөн БНСУ-д төрсөн хүүхэд өсч томрохдоо хэрэв бүрэн боловсрол эзэмшиж, бүрэн эрүүл мэндтэй байснаас 80 хувийн бүтээмжтэй байх болно. Энэ нь Зүүн Ази, Номхон далайн бүсийн дундаж (59 хувь) болон Өндөр орлоготой орнуудын дундаж (71 хувь)-аас өндөр байна



Монгол Улс дахь Хүмүүн капиталын индекс

- ▶ Цар тахлын өмнөхөн Монгол Улсад төрсөн хүүхэд өсч томрохдоо хэрэв бүрэн боловсрол эзэмшиж, бүрэн эрүүл мэндтэй байснаас 61 хувийн бүтээмжтэй байх болно. Энэ нь Зүүн Ази, Номхон далайн бүсийн дундаж (59 хувь) болон Дундаас доогуур орлоготой орнуудын дундаж (48 хувь)-аас өндөр байна. Харин энэхүү үзүүлэлт нь БНСУ-ынхтай харьцуулахад 23.8 хувиар доогуур байна.

НҮБ-ын шинжээчид, судлаачдын үзэж байгаагаар нийгмийн тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл нь хүний хөгжил, мөн хүмүүн капиталын хэмжээ, чанар байдаг. Хүмүүн капиталын индекс нь өнөөдөр төрсөн хүүхэд 18 нас хүртлээ амьдарч буй улсынхаа эрүүл мэнд, боловсролын түвшин доогуур байгаатай холбоотой өрсдэлийг харгалзан хуримтлуулж чадах хүмүүн капиталын хэмжээний үзүүлэлт юм. Монгол Улс, БНСУ дахь хүмүүн капиталын индексийг Хүснэгт 3,4-өөс харъя.

2018-2020 оны Хүмүүн капиталын индекс (ХКИ)-ийг харьцуулж үзэхэд, БНСУ-д 0.79877627 болж -4.3 хувь, Монгол Улсад 0.61439753 болж -0.5 хувиар тус тус буурсан байна. Гэхдээ манай орны ХКИ нь БНСУ-ынхаас даруй 23.1 хувиар доогуур байгаа бөгөөд харин БНСУ-ын ХКИ нь АНУ-ынхаас 13.8 хувиар дээгүүр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Зүүн хойд Азийн орнууд дахь хүмүүн капиталын индекс

№	Улс орны нэр	2010	2011	2016	2017	2018	2019	2020	Өсөлт+, бууралт– 2020/2018
1.	БНХАУ	-	-	-	0.67	0.64709884	-	0.65310264	+0.9
2.	Япон	0.8161857	-	-	0.84	0.84070921	-	0.80471426	-4.3
3.	БНСУ	0.8246274	-	-	0.85	0.83454508	-	0.79877627	-4.3
4.	БНАСАУ	-	-	-	-	-	-	-	-
5.	Монгол	-	-	-	0.63	0.61730927	-	0.61439753	-0.5
6.	ОХУ	0.60054857	-	-	0.73	0.72895044	-	0.68141961	-6.5
7.	АНУ*	0.69150817	-	-	0.76	0.71368320	-	0.70176435	-1.7

БНСУ	Монгол Улс
• 5 нас хүртлээ эсэн мэнд үлдэх магадлал	
БНСУ-д төрсөн 100 хүүхэд тутмын 100 нь 5 хүртэл насалдаг.	Монгол Улсад төрсөн 100 хүүхэд тутмын 98 нь 5 хүртэл насалдаг.
• Хүлээгдэж буй сургалтын жил	
БНСУ-д 4 настайдаа сургуульд орсон хүүхэд 18 нас хүртлээ 13.6 жил сурна гэж тооцдог.	Монголд 4 настайдаа сургуульд орсон хүүхэд 18 нас хүртлээ 13.2 жил сурна гэж тооцдог (Солонгостой харьцуулахад 97.1 хувь).
• Тохиромжтой тестийн оноо	
Хамгийн өндөр амжилт нь 625, хамгийн бага амжилт нь 300 оноотой ангиллаар БНСУ-ын суралцагчид 537 оноо авдаг.	Энэхүү ангиллаар Монголын суралцагчид 435 оноо авдаг (Солонгостой харьцуулахад 81 хувь).
• Суралцсан хичээлийн жил	
Хүүхдүүдийн сурсан зүйлийг тооцож үзэхэд сургуульд суралцах хугацаа ердөө 11.7 жил байна.	Хүүхдүүдийн сурсан зүйлийг тооцож үзэхэд сургуульд суралцах хугацаа ердөө 9.2 жил байна (Солонгостой харьцуулахад 78.6 хувь).
• Насанд хүрэгчдийн амьд үлдэх хувь	
БНСУ-д 15 настай хүүхдүүдийн 94 хувь нь 60 хүртэл насална. Энэхүү мэдээлэл нь өнөөдөр төрсөн хүүхэд насанд хүрсэн үедээ эрүүл мэндэд учирч болох эрсдэлийн хүрээг харуулдаг.	Монгол Улсад 15 настай хүүхдүүдийн 80 хувь нь 60 хүртэл насална (Солонгостой харьцуулахад 85.1 хувь).
• 5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хоцрогдолгүй хэсэг	
Олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой, хүүхдийн өсөлтийн хоцрогдолттой холбоотой мэдээлэл БНСУ-д байхгүй.	100 хүүхдийн 91 нь хоцрогдолгүй байна. 100 хүүхэд тутмын 9 нь насан туршдаа үргэлжлэх танин мэдэхүйн болон бие бялдрын хомсдолд орох эрсдэлтэй байдаг.

Монгол Улс, БНСУ, Япон дахь хүмүүн капиталын индекс

Хүснэгт 5

Үзүүлэлт	Монгол Улс			БНСУ			Япон		
	Нийт	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид
Хүмүүн капиталын индекс (ХКИ)	0.61	0.59	0.64	0.80	0.78	0.81	0.80	-	-
5 хүртэлх насанд амь үлдсэн	0.984	0.981	0.987	0.997	0.997	0.997	0.998	0.997	0.998
Сургалтын хүлээгдэж буй хугацаа	13.2	13.1	13.2	13.6	13.6	13.6	13.6	-	-
Тестийн тохируулсан оноо	435	435	434	537	535	540	538	537	539
Насанд хүрэгчдийн амь үлдсэн хувь	0.796	0.715	0.879	0.945	0.922	0.968	0.949	0.933	0.965
Өсөлтийн дутагдалгүй хүүхдийн эзлэх хувь	0.906	0.891	0.922	-	-	-	-	-	-

БНАСАУ, БНХАУ, ОХУ дахь хүмүүн капиталын индекс

Хүснэгт 6

Үзүүлэлт	БНАСАУ			БНХАУ			ОХУ		
	Нийт	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид
Хүмүүн капиталын индекс (ХКИ)	-	-	-	0.65	0.65	0.66	0.68	0.64	0.73
5 хүртэлх насанд амьд үлдсэн	-	-	-	0.991	0.991	0.992	0.993	0.992	0.994
Сургалтын хүлээгдэж буй хугацаа	-	-	-	13.1	13.1	13.2	13.7	13.7	13.7
Тестийн тохируулсан оноо	-	-	-	441	441	441	498	494	501
Насанд хүрэгчдийн амьд үлдсэн хувь	-	-	-	0.924	0.908	0.941	0.804	0.716	0.891
Өсөлтийн дутагдалгүй хүүхдийн эзлэх хувь	-	-	-	0.919	0.919	0.919	-	-	-

Монгол Улсын хүний хөгжлийн индекс (ХХИ) сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр байгаа учраас олон улсын түвшинд хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын тоонд 2015 оноос орсон билээ. Дэлхийн хүний хөгжлийн 2021/2022 оны илтгэлд дурдсанаар БНСУ, Япон улс 19-д, АНУ 21-д, умард хөрш ОХУ 52-т эрэмбэлэгдэж, хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнуудын эгнээнд, өмнөд хөрш БНХАУ 79-д, манай орон 96-д эрэмбэлэгдэж, хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын эгнээнд багтаж байна.

Дэлхийн зарим орнуудын хүний хөгжлийн индекс

Тухайн орны ХХИ-ийн эрэмбэ (2021)	Хүний хөгжлийн индекс ХХИ 2021	Төрөлтөөс тооцсон дундаж нас (жилээр) 2021	Сургалтын хугацаа (жилээр)		Нэг хүнд ногдох ҮНО (худалдан авах чадварын 2017 оны паритетээр ам.доллар) 2021	Нэг хүнд ногдох ҮНО-ын эрэмбээс ХХИ-ийн эрэмбийг хасах нь 2021	
			хүлээгдэж буй 2021	дундаж 2021			
<i>Хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд</i>							
19	Япон	0,925	84,8	15,2	13,4	42 274	12
19	БНСУ	0,925	83,7	16,5	12,5	44 501	9
21	АНУ	0,921	77,2	16,3	13,7	64 765	-14
52	ОХУ	0,822	69,4	15,8	12,8 ^j	27 166	-1
<i>Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд</i>							
79	БНХАУ	0,768	78,2	14,2 ^j	7,6 ^f	17 504	-8
96	Монгол	0,739	71,0	15,0^j	9,4^m	10 588	9
Хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд		0,896	78,5	16,5	12,3	43 752	-
Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд		0,754	74,7	14,2	8,3	15 167	-
Хүний хөгжлийн дунд түвшинтэй орнууд		0,636	67,4	11,9	6,9	6 353	-
Хүний хөгжлийн бага түвшинтэй орнууд		0,518	61,3	9,5	4,9	3 009	-
Нийт дэлхий		0,732	71,4	12,8	8,6	16 752	-

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2021/2022-д дурдсанаар, хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд дахь ХХИ 0,896 байгаа бөгөөд энэхүү ангилалд багтдаг БНСУ-ын ХХИ эл дунджаас 0,029 нэгжээр илүү байна. Гэтэл хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд дахь ХХИ 0,754 байгаа бөгөөд энэхүү ангилалд багтдаг Монгол Улсын ХХИ энэ дунджаас 0,015 нэгжээр дутуу байгаа аж.

Хүний хөгжлийн индексийн 2015-2021 оны өөрчлөлтөөс үзэхэд, БНСУ-ын хүний хөгжлийн индексийн эрэмбэ 3 нэгж, манай орных 4 нэгжээр урагшилсан байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн зургаан жилд БНСУ болон манай оронд хүний хөгжил ахицтай байгаа нь харагдаж байна.

Манай орны нэг хүнд ногдох ҮНО 2021 онд 10588 ам.доллар, БНСУ-д 44501 ам.доллар болж, манай орныхоос даруй 4.2 дахин их байгаагаас үзэхэд, манай орны хүн амын амьжиргааны түвшин нэлээд доогуур байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын дэлхийн дундаж 16 752 ам.доллар байгаа бөгөөд БНСУ-ын нэг хүнд ногдох ҮНО дэлхийн дунджаас 2.7 дахин их, харин манай орных дэлхийн дунджийн 2/3-той тэнцэж байна.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт БНСУ-д 83.7 жил байгаа нь хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнуудынхаас 5.2 жилээр илүү байгаа бөгөөд манай оронд 71.0 жил байгаа нь хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудынхаас даруй 3.7 жилээр бага байгаа ажээ.

Жини коэффициент 2000-2021 онд БНСУ-д 32.7, Монгол Улсад 31.4 байна. Манай орны хүн амын хамгийн чинээлэг 10 хувийнхний орлогод эзлэх хувь хэмжээ 25.7 байхад БНСУ-д 24.0 байгаагаас үзэхэд, манай оронд орлогын хуваарилалтын тэгш бус байдал БНСУ-ынхаас ялимгүй их байна гэсэн үг юм.



Дүгнэлт

1. Хүний хөгжлийг бүхий л талаар хангаж, нэгэнт бий болсон хүмүүн капиталыг бүрэн дүүрэн ашигласнаар л БНСУ-ын эдийн засгийн огцом өсөлт бий болжээ гэсэн дүгнэлт хийж болно.

2. Цаашид Монгол Улс, БНСУ-ын эдийн засаг, худалдааны харилцааг бүхий л талаар өргөжүүлэн хөгжүүлэхэд Зүүн хойд Азийн орнуудын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа чухал нөлөөтэй ажээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

проф. Ч.Улаан

Цахим шуудан: ulaanninjee@gmail.com